ХУРГАТАЙ
ХАЙРХАН




# ХОБОМ хөтөлбөрийн анхны уулзалт зохион байгуулагдлаа

ХУРГАТАЙ ХАЙРХАН

Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг (ХОБОМ)-ийн хөтөлбөрийн анхны уулзалт 2026 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр “Овоот” төслийн талбайд болж, орон нутгийн 10 малчин оролцлоо.

Уулзалтын үеэр төслийн талбайд суурилуулж буй агаарын чанарын автомат станцуудын ажиллагаа, хэмжилтийн талаар мэргэжлийн байгууллагын төлөөлөл танилцуулав.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

“Хургатай Хайрхан” ХХК-ийн Байгаль орчны менежер Г.Гүнбат ХОБОМ-ийн зорилго, ач холбогдлыг танилцуулж, оролцогчдын асуултад хариуллаа.

***“Эдгээр станц нь төслийн талбай болон ойр орчмын агаарын чанарыг тасралтгүй хэмжиж, мэдээллийг компанийн вебсайтаар 24 цаг дамжуулан олон нийтэд нээлттэй хүргэнэ. Мөн хэмжилтийн үр дүнг тогтмол мэдээлж, орон нутгийн иргэд, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавина. ХОБОМ-ийн гол зорилго нь байгаль орчноо хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг хангаж, талуудын оролцоо, харилцан итгэлцэлд тулгуурласан хамтын хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэнэ.”***



**Г.Гүнбат**

“Хургатай Хайрхан” ХХК-ийн
Байгаль орчны менежер

ХУРГАТАЙ ХАЙРХАН

Оролцогчид хөтөлбөрийн цаашдын үйл ажиллагаа, агаар, ус, хөрсний хэмжилт, дээжлэлт, уулзалтын давтамж болон мэдээлэл солилцох хэлбэрийн талаар санал солилцлоо.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

*Байгальд ээлтэй*
*Орон нутагт өгөөжтэй*



*Зураг. Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, Ногоон нуур, 2024 он*